



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ  
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД  
ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р  
хороо, Самбуугийн гудамж-22, Зоос гоёл-317  
Утас: +976-70140166, 70140188,  
Э-шуудан: piubaccp@gmail.com,  
<http://www.baccp.mn>

2023.07.07 № 63/23

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН  
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭСТ

Төслийн үйл ажиллагааны тайланг  
хүргүүлэх тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн II,III шатны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг 2023 оны хагас жилийн байдлаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтын дагуу гарган, хүргүүлж байна.

Хавсралтад хуудастай.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

М.БОЛДБАЯР



Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын  
хавсралт Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,  
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд  
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх  
нийтлэг журмын хүснэгт 5

**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ  
ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БҮЙ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ,  
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II/III ТӨСЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)

<b>№</b>	<b>Төслийн агуулга</b>	<b>Гүйцэтгэл</b>
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	<p><b>Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II/III төсөл</b></p> <p><b>Шийдвэр:</b></p> <p><b>БОЯБХУАӨДЗ II төсөл:</b> Монгол-Германы Засгийн газар хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр</p> <p><b>БОЯБХУАӨДЗ III төсөл:</b> Монгол-Германы Засгийн газар хооронд 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр</p> <p><b>Төслийн дугаар:</b> BMZ 2016 67 054; BMZ 2018 68 272</p> <p><b>Төслийн зорилго:</b> Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/ холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.</p>
2	Санхүүжилтийн эх үүсвэр	ХБНГУ-ын Засгийн газар <b>Буцалтгүй тусламж</b> Монгол Улсын Засгийн газар
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, БОАЖЯ-ны ТХГНБЗГ, ТХГН-ийн хамгаалалтын захиргаад</p> <p>Хэрэгжих хугацаа: 6 жил: 2020.03.02 - 2026 /II, III үе шат/</p>
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1:</b> Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслэлээр хангах;</p> <p><b>Зорилт 2:</b> Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p> <p><b>Зорилт 3:</b> Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;</p> <p><b>Зорилт 4:</b> Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан</p>

			сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;			
5	Зардал	Төсөв (Нийт зардал)	Төслийн II,III шатны нийт төсөв 32.8 сая евро. ХБНГУ-ын Засгийн газар 27.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 14.8 тэрбум төгрөг			
		Үүнд:	Төсөв (2023 он)	Гүйцэтгэл		Хувь
		ХБНГУ-ын Засгийн газар	25,352,100,00 0.00 төгрөг	1,529,542.96 евро	5,506,354,672.00 төгрөг	22%
		МУ-ын Засгийн газар	880,000,000.0 0 төгрөг	100,942.27 евро	363,392,174.73 төгрөг	41%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу биелэлтийг гаргав.				
	1-р зорилтын хүрээнд: <b>Хүрэх үр дүн:</b> Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслэлээр хангах;	<p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Гэр бүл</p> <p>2.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.</p> <p>2.4.10. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтээт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.</p> <p><b>1. Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /УАТ 1.01./:</b></p> <p>Төслийн 1-р шатны ОБЗЭС-гийн үйл ажиллаганд мониторинг хийх, 2,3-р үе шатанд хэрэгжүүлэх сумдыг сонгож сургалт хийх зөвлөх үйлчилгээг хамт төлөвлөж нэг удаа тендер зарласан боловч амжилтгүй болсон. Санхүүжүүлэгч байгууллагын саналаар 1-р үе шатны үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэсний дараа 2, 3-р үе шатны сургалтыг зохион байгуул гэсэн шийдвэр гарсны дагуу хөндлөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний тендерийг тус оны 06 дугаар сарын 27-ны өдөр хүлээн авч, үнэлгээ хийж байна. 2023 оны 07 дугаар сард багтаан гэрээ байгуулахаар ажиллаж байна. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 50% хоцрогдолтой.</b> /2022.08 сараас эхэлсэн ажил/</p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин</p> <p>2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гол түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.</p>				

	<p><b>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</b> Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслэлээр хангах;</p> <p>2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p><b>2. Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /YAT 1.02./: 2022 онд байгуулсан 330,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл/202202013, 22/178 дугаартай тус шатчилсан гэрээт ажлыг "Некст степ инженеринг" ХХК нь 2022 оны 08 дугаар сарын 01 өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр гэрээнд заасан байдаг.</b></p> <p>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага эхлэлийн тайлан, Хустайн БЦГ-ын Х3-ны байгаль хамгаалагч, судлаачдын байрны засварын ажлын даалгавар, 2 удаагийн хяналт тавьсан тайланг ирүүлсний дагуу гүйцэтгэгчийн эхний санхүүжилтийг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр шийдвэрлэж олгосон.</p> <p>Гэрээний дагуу тайлангийн хугацаанд жилийн ажлын төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлж гүйцэтгэлийг үнэлэх ба гэрээний ерөнхий нөхцөлийн 3 дугаар бүлгийн 3.1 болон 3.2 дахь заалт, гэрээний тусгай нөхцөлийн 8.1 дүгээр заалт, гэрээний баримт бичгийн 3 дугаар хавсралтын 5 болон 14 дүгээр заалтыг тус тус мөрдөж, хамтран ажиллахыг төслийн зохицуулагчийн 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 37/23 дугаар албан бичгээр мэдэгдэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг удаа дараа шаардсан боловч хариу арга хэмжээ аваагүй, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан ирүүлээгүй. <b>Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 0%</b></p> <p><b>3. Байгаль хамгаалагчийн байр болон бусад барилгын хөрсний геологи, геодезийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /YAT 1.03./:</b></p> <p>Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай тушаал болон тушаалд өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулан баталгаажуулсан.</p> <p>Ажлын даалгавар хэлэлцэх хурлыг захиалагч, төслийн зөвлөх баг болон Төслийн барилгын зөвлөх баг "Некст степ инженеринг" ХХК болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийг оролцуулан (2023 оны 01 дүгээр сарын 11 болон 31-ний өдөр, 02 дугаар сарын 17-ны өдөр, 03 дугаар сарын 09-ний өдөр, 06 дугаар сарын 22-ны өдөр) хэлэлцүүлгийг зохион байгуулсны дунд захиалагчаар ажлын даалгаврыг тус оны 04 дүгээр сарын 17-ны өдөр батлуулан, тендер зарлах бэлтгэл ажлыг хангаад байгаа хэдий ч тус тендерийг олон нийтэд зарлахыг хойшлуулах тухай имэйл Төслийн зөвлөх багийн техникийн ахлах зөвлөх Александр Градел ирүүлснээр түр хойшлоод байна. <b>Ажлын гүйцэтгэл</b></p>
--	--

	<p><b>төлөвлөгөөний дагуу 30% хоцрогдолтой /2023.02 сард тендер зарлахаар төлөвлөгөөнд туссан./</b></p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</p> <p>6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохицтой менежментийг хэрэгжүүлнэ.</p> <p><b>4. Кластерт хамрагдсан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад болон байгаль орчны байгууллагуудыг шаардлагатай судалгааны багаж төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /УАТ 1.04./:</b></p> <p><b>Багц 1:</b> “Судалгааны тоног төхөөрөмж”: БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь 2022 онд байгуулсан MONNCB-02/0321, №22/295 дугаар гэрээний дагуу 691,982.86 европийн үнийн дүн бүхий 14 төрлийн нийт 1923 ширхэг тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, хадгалалтын байдал болон холбогдох баримтуудтай 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр газар дээр нь танилцан, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг туршин шалгаж биет байдлын болон эрхийн доголдолгүй, гэрээнд заасан техникийн үзүүлэлтийн дагуу тоо ёсоор бүрэн хүлээлцсэн болно.</p> <p>Гүйцэтгэгч нь гэрээний дагуу Ховд, Увс, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн байгаль орчны нийт 45 байгууллагын дарга, мэргэжилтэн нарт угсралт, суурилуулалт, ашиглалтын талаар онол, практикийн сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хийж, заавар, зөвлөмжийг өгч, гарын авлагаар ханганд, актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. <b>Ажлын гүйцэтгэл 100%.</b></p> <p><b>Багц 2:</b> “Цаг уурын автомат станц” БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь 2022 онд байгуулсан MONNCB-02/0321, №22/290 дугаар гэрээний дагуу 104,396.00 европийн үнийн дүн бүхий 4 иж бүрдэл Цаг уурын автомат станцыг техникийн тодорхойлолт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, хадгалалтын байдал болон холбогдох баримтуудтай 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр газар дээр нь танилцан, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг туршин шалгаж биет байдлын болон эрхийн доголдолгүй, гэрээнд заасан техникийн үзүүлэлтийн дагуу тоо ёсоор бүрэн хүлээлцсэн болно. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу Ховд, Увс, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн</p>
--	---

	<p>Ус, цаг уурын орчны шинжилгээний төвийн дарга, мэргэжилтэн нарт угсралт, суурилуулалт, ашиглалтын талаар онол, практикийн сургалтыг 2023 оны 04 дугаар сарын 06-ны өдөр хийж, заавар, зөвлөмжийг өгч, гарын авлагаар ханган, актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. <b>Ажлын гүйцэтгэл 100%.</b></p> <p>Ажлын үр дүнд байгаль орчны судалгаа, сургалтын чанарыг сайжруулах, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарын чадавхыг бэхжүүлэх болон цаг уурын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зарлан мэдээлэх, цаг алдалгүй арга хэмжээ авах ажлыг сайжруулах зорилготой. <b>Ажлын гүйцэтгэл дунджаар 100%.</b></p> <p><b>5. Төсөлд хамрагдсан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад болон байгаль орчны байгууллагуудыг шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /УАТ 1.05./:</b></p> <p><b>Багц 1:</b> 2022 онд зарласан тус тендерийн "Үндсэн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлэх" багц 1 тендер амжилтгүй болсон тул үнэлгээний хорооны 01 дугаартай хурлыг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, тендер амжилтгүй болсон шалтгааныг судласны дагуу ажлын даалгавар болон тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулж, дахин зарлах зөвшөөрөл (NOL)-ийг KfW-aas 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр авсан. Тендерийг тус оны 05 дугаар сарын 02-ны өдөр дахин зарласан ба тендерийг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нээж үнэлгээ хийж байна. 2023 оны 07 дугаар сард багтаан гэрээ байгуулахаар ажиллаж байна. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 50% хоцрогдолтой /2023.08 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./</b></p> <p><b>Багц 2:</b> БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/13 дугаар тушаалаар "Гэрээ байгуулах эрх олгох, хөрөнгө гаргах" тушаалын дагуу тендерт шалгарсан "Евро урлан" ХХК-тай 284,419,000 төгрөгийн үнийн дүн бүхий MONNCB-02/321, 23/02 дугаар гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу нийлүүлэх 11 нэр төрлийн 208 ширхэг оффисын тавилга, IT тоног төхөөрөмжийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ажиллаж актаар хүлээн авсан. Хуваарилалтын дагуу оффисын тавилга, IT тоног төхөөрөмж хүлээн авч буй БОАЖЯ, Дарьгангын БЦГ, Ачит нуур-Дэвэл арлын БЦГ, Гутайн даваа-Хөмүүл голын эхийн БЦГ, Тэсийн гол-Булнайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны холбогдох албан хаагчдад зохистой ашиглалт, аюулгүй ажиллагааны чиглэлээр заавар зөвлөмж өгч, угсралт, тээвэрлэлтийн үеийн эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулснаар 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр</p>
--	--

	<p>актаар хүлээлгэн өгөв. <b>Ажлын гүйцэтгэл 100%. Ажлын гүйцэтгэл дунджаар 70%.</b></p> <p>Ажлын үр дүнд БОАЖЯ болон шинээр улсын тусгай хамгаалалтад авсан 4 газар нутгийн хамгаалалтын захиргаадын материаллаг базыг бэхжүүлж, мэргэжилтэн, байгаль хамгаалагчид үндсэн тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдсанаар ажиллах нөхцөл сайжирч, албан үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр үзүүлнэ.</p> <p><i>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</i></p> <p>6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.</p> <p><b>6. Сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд: /УАТ 1.06/:</b></p> <p>Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуультай 2022 онд байгуулсан 65,880,000 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-22/22, 22/278 дугаартай гэрээний дагуу сонгогдсон ЗТХГН-ийн түлхүүр зүйлүүдийн суурь мэдээллийг бүрдүүлэх талбай, арга зүй, үр дүнг нэгтгэх, тайлagnах ажлын талаарх төлөвлөгөө буюу эхлэлийн тайланг хүлээн авснаар эхний санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байсан. Тус онд гэрээний дагуу Говь Гурван сайханы БЦГ-т Цоохор ирвэс, Аргаль хонь, Хар сүүлт, Их газрын чулууны БЦГ-т Аргаль хонь, Монгол тарвага, Дарьганын БЦГ-т Аргаль хонь, Монгол Тарвага, Цагаан зээрийн биологийн олон янз байдлын түлхүүр зүйлүүдийн тархалт, нөөц, сүргийн бүтэц, нүүдэл шилжилт хөдөлгөөн (еко коридор) нутгуудыг тодорхойлох суурь мэдээллийг бүрдүүлэх хээрийн судалгааны ажил болон суурин боловсруулалын ажил дуусч, тайланг 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ТХН-д ирүүлээд байна. БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/65 дугаар тушаалаар томилогдсон БОЯБ-ын мэргэжлийн зөвлөл нь тус ажлын тайланг хэлэлцэх зөвлөлийн хурлыг 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гэрээг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дүгнэсэн.</p> <p><b>Ажлын гүйцэтгэл 100%.</b></p> <p>Ажлын үр дүнд тогтоосон шалгуурын дагуу сонгосон 7 УТХГ буюу Говийн бага ДЦГ, Нэмрэгийн ДЦГ, Их газрын чулууны БЦГ, Дарьганын БЦГ, Их Богдын БЦГ, Монгол элсний БЦГ, Говь гурван сайхны БЦГ-ын биологийн олон янз байдлын суурь судалгаа бүрдэж байна.</p>
--	---

	<p><b>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</b></p> <p>6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохицтой менежментийг хэрэгжүүлнэ.</p> <p><b>7. Төсөлд хамрагдсан сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчид болон бусад тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын ажилтнуудыг 4 улирлын дүрэмт (919) хувцсаар хангах ажлын хүрээнд /УАТ 1.07/: Хилийн цэргийн 0288 дугаар анги ТӨААТҮГ-тай 2022 онд байгуулсан 694,640 еврогийн үнийн дүн бүхий MONNCB-04/22, 22/373 дугаар гэрээний дагуу БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь эхний гүйцэтгэл буюу 10 нэр төрлийн 7358 ширхэг хувцас хэрэглэлийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 2023/01 дугаар актаар хүлээн авсан ба төсөлд хамрагдсан байгаль орчны 32 байгууллагад батлагдсан хуваарилалтын дагуу актаар хүлээлгэн өгсөн. Гэрээний дагуу эцсийн гүйцэтгэл буюу 7 нэр төрлийн 4637 ширхэг хувцсыг 2023 оны 09 дүгээр сард багтаан хүлээн авахаар ажиллаж байна. <b>Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 70% хоцрогдолтой.</b> /2023.06 сард багтан хүлээлгэн өгөхөөр гэрээнд туссан./</b></p> <p>Ажлын үр дүнд Төсөлд хамрагдсан сумдын БХ, БО-ны хяналтын улсын байцаагчид болон бусад ТХГН-ийн ХЗ-дын 919 хүний оффисын болон хээрийн ажлын зориулалт бүхий 4 улирлын 17 нэр төрлийн иж бүрэн дүрэмт хувцсаар хангагдсанаар нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх баталгаагаар хангагдаж, шинэ өнгө төрх, эрч хүчтэйгээр ажил үргээ гүйцэтгэх болсон.</p> <p><b>8. Байгаль орчны байгууллагуудад бартаат замын автомашин нийлүүлэх ажлын хүрээнд /УАТ 1.08./:</b> БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/544 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдсан. Тус ажлын худалдан авах ажиллагааг үйл ажиллагааны тус төлөвлөгөөний 3.02 ажил болох “Сонгогдсон 7 хамгаалалтын захиргаанд бартаат замын автомашин нийлүүлэх” ажилтай хамтатган зохион байгуулж байгаатай холбогдуулан 16 автомашин нийлүүлэх хамгаалалтын захиргаад болон БОАЖГ-уудын нэrsийг тодруулсны дагуу 11 нь байгууллага хуваарилалтыг ирүүлсэн 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ажлын даалгавар, 27-ны өдөр тендерийн баримт бичиг тус тус батлагдаж, 28-ны өдөр тендерийг зарласны дагуу тендерийн нээлтийг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хийх байсан</p>
--	---

	<p><b>1-р зорилтын хүрээнд:</b>  <b>Хүрэх үр дүн:</b>          Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслэлээр хангах;</p>	<p>боловч ганц ч компани тендерийн материал ирүүлээгүй шалтгаанаар тендерийн нээлт амжилтгүй болсон. Үнэлгээний хороог 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр дахин хуралдуулж тендерийг 2023 оны 04 дүгээр сарын 5-нд 30 хоногийн хугацаатай дахин зарласан хэдий ч ганц ч компаниас тендерийн материал ирээгүй тул тендер амжилтгүй болсон үндэслэл шалтгааныг судалж үзэн, үнэлгээний хороог 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр дахин хуралдуулж ажлын даалгавар болон тендерийн баримт бичгийг ТНБД-аар шинэчлэн батлуулан, тендерийг дахин зарласан. Тендерийн нээлтийг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хийхээр ажиллаж байна. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 30 % /2023.08 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан.</b> Ажлын дүнд тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлснээр хамгааллын арга хэмжээ сайжирч, байгаль орчны хяналт мониторингийн чадавхийг нэмэгдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлэх зорилготой.</p> <p><b>Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 1-ийн хүрээнд нийт 8 ажил төлөвлөснөөс 2 ажил 100%, 2 ажил 70%, 1 ажил 50%, 2 ажил 30%, 1 ажил 0%-тай үнэлэгдэж байна.</b> Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын гэрээг цуцлах талаар удирдах хороонд танилцуулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авна. <b>Зорилт 1-ийн ажлын дундаж үнэлгээ 56,3 %.</b></p>
	<p><b>2-р зорилтын хүрээнд:</b>  <b>Хүрэх үр дүн:</b>          Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</p> <p><b>6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохицтой менежментийг хэрэгжүүлнэ.</b></p> <p>1. Баруун бүсийн сургалт судалгаа, мэдээллийн төвийн барилга барих ажлын хүрээнд /УАТ 2.01/: ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн (KfW) банкны явцын үнэлгээний баг 2023 оны 06 сард Монголд ажилласан томилолтын үр дүнд гарсан хурлын тэмдэглэлд: "Санал болгож буй төвийн хэрэгцээний нарийвчилсан үнэлгээ, үйл ажиллагааны нарийвчилсан/сэтгэлд хүрсэн үзэл баримтлалыг өнөөг хүртэл боловсруулж KfW-д хянуулаагүй байгаа тул цаашид шийдвэр гаргах үндэслэл байхгүй байна. Гэсний дагуу БОАЖЯ нь 2023 оны 08 дугаар сарын сүүлээс өмнө санал болгож буй барилгыг хэрхэн үргэлжлүүлэх талаар санал бэлтгэхээр хоёр тал тохирсон. Мөн томилолтын ажлын үеэр төслийн 1 шатанд баригдаж, 2018 онд хүлээлгэн өгсөн Хангайн бүсийн төвийн үйл ажиллагааг зөвхөн Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны төсвөөр хэрэгжүүлдэгтэй холбогдуулан санхүүжүүлэгч талаас төвийн үйл ажиллагааны зардлыг ирэх онд шийдээгүй тохиолдолд</p>

	<p>дахин бүсийн төв барих боломжгүйг илэрхийлсэн. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хугацаа болоогүй тул үнэлэхгүй.</b> /2023.10 сард тендерийг зарлахаар төлөвлөгөөнд туссан./</p> <p>БОАЖЯ-наас УТХГ-ын Хангайн бүсийн төвийн үйл ажиллагааны урсгал зардал, төсвийг батлуулах, баруун бүсийн төвийн хэрэгцээ, шаардлага, цаашдын үйл ажиллагааны тогтвортой байдлын талаар концепцийг хүргүүлсний дараа тус ажлыг эхлүүлнэ.</p> <p><b>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил</b>  <b>2.1.25. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ.</b></p> <p><b>2. Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинетыг сургалтын гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /YAT 2.02/:</b>  БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/76 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулсан. БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнээс “Эко танхим” төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын талаарх албан бичгийг боловсруулан батлуулж, хамtran ажиллах тухай 01/2886 дугаартай албан бичгийг 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр БШУ-ны сайд Л.Энх-Амгаланд хүргүүлсэн. Тендерийн ажлын даалгаврыг 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, тендерийн баримт бичгийг 30-ны өдөр захиалагчаар тус тус батлуулсны дагуу 30-ны өдрөө 9 хоногийн хугацаатай олон нийтэд зарласан. Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 07 дугаар сарын 07-ны өдөр <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%</b> /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./</p> <p><b>3. Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /YAT 2.03/:</b>  БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр А/48 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулсан. Хэрэгцээт байдлын судалгаа, үнийн судалгаа, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын төслийг орон нутгийн баг, зөвлөх баг боловсруулж ТХН-д 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн. Тендерийн ажлын даалгавар 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр захиалагчаар батлагдсан. Батлагдсан ажлын даалгаварт 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр БОАЖЯ болон БШУЯ-</p>
--	---

	<p>наас сургуулийн жагсаалт болон зарим барааны техникийн үзүүлэлтэд оруулсан өөрчлөлтийг зөвлөх багаас хүлээж авсны дагуу тендерийн үнэлгээний хорооны 01 хурлыг 25-ны өдөр зохион байгуулж, тендерийн баримт бичгийг захиалагчаар 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр батлуулан тендерийг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зарласан. Тендер хүлээн авах хугацаа 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100% /2024.02 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./</b></p> <p><b>4. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах ажлын хүрээнд /УАТ 2.04/: БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний А/47 дугаар тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулгасан. Үнэлгээний хорооны №01 хурлыг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичгийн төслийг авч хэлэлцэж, ажлын даалгаврыг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр, тендерийн баримт бичгийг 28-ны өдөр тус тус батлуулсан ба 29-ний өдөр тендерийг олон нийтэд нээлттэй зарласан. Тендерийг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр нээхээр төлөвлөн ажиллаж байсан боловч тендерийн нээлттэд ганц ч компанийн материал ирээгүй тул стандартын дагуу бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн машиныг нийлүүлэх асуудлыг удирдах хорооны хурлаар хэлэлцүүлж тус тендерийн төсөвт өртгийг нэмэх эсвэл худалдан авах машины тоо хэмжээг багасгах талаар нэгдсэн шийдвэр гарсны дараа тендерийг дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 0% /2023.10 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./</b></b></p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</p> <p><u>6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</u></p> <p><b>5. Баруун бүсийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг мотоциклоор хангах ажлын хүрээнд /УАТ 2.05/:</b> БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/70 дугаар тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. БОАЖЯ-наас 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ажлын даалгавар нь хуваарилалтын хүснэгтгүйгээр батлагдан үнэлгээний хороонд ирсэнтэй холбогдуулан санхүүжүүлэгч байгууллагаас хуваарилалтын хүснэгттэй</p>
--	--

	<p>байхыг шаардсаны дагуу 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хуваарилалтыг батлуулж, тендерийг тус сарын 29-ний өдөр зарласан. Тендер хүлээн авах хугацаа 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдөр. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 30% /2023.11 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./</b></p> <p><b>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин</b></p> <p>2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гол түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.</p> <p>2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p><b>6. Байгаль хамгаалагчийн 12 байр барих ажлын хүрээнд /УАТ 2.06/:</b></p> <p>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.03-д төлөвлөсөн Байгаль хамгаалагчийн байр болон бусад барилгын хөрсний геологи, геодезийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажилтай уялдан хийгдэх бөгөөд барилгын ажлын зураг төслийн гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалт зохион байгуулагдаж, барилгын ажлын зураг төслийг гүйцэтгэж, магадлаалаар оруулж батлуулсны дараа барилгын ажлын гүйцэтгэгч сонгох тендерийн үнэлгээний хороог 2023 оны 09 сард байгуулж, тендерийг 10 сард зарлахаар төлөвлөсөн. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хугацаа болоогүй тул үнэлэхгүй. /2023.08 сард тендерийг зарлахаар төлөвлөгөөнд туссан./</b></p> <p><b>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</b></p> <p>6.1.5. <u>Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</u></p> <p><b>7. Цахим хурлын тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /УАТ 2.07/:</b></p> <p>“Ай Ти Эс Өү” ХХК-тай 2022 онд байгуулсан 574,147,000 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл/202207044, №22/322 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ажиллаж тоног төхөөрөмжийн техникийн</p>
--	---

	<p><b>2-р зорилтын хүрээнд:</b>  <b>Хүрэх үр дүн:</b>  Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p> <p>шаардлага болон гэрээнд тусгагдсан нөхцлийн дагуу шалгаж 2023/02 дугаартай актаар хүлээн авсан. Батлагдсан хуваарийн дагуу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс, Баянхонгор, аймгийн БОАЖГ-т 3 нэр төрлийн 15 ш, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий аймгийн сумдад 3 нэр төрлийн 95 ш, Говь-Алтай аймгийн ИТХ, Увс аймгийн ЗДТГ тус тус 4 нэр төрлийн 4 ш, БОАЖЯ 2 төрлийн 2ш зэрэг нийт 7 нэр төрлийн 120 ширхэг ухаалаг дэлгэц, дууны өсгөгч, ухаалаг дэлгэцийн хөл, вэб камерийн ком, лед дэлгэц, лед дэлгэцийн удирдлага, зөөврийн компьютер зэрэг цахим хурлын тоног төхөөрөмжийг 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 16 хоногийн хугацаанд баруун 5 аймаг, 30 сум тус бүрд тээвэрлэн хүргэж, угсарч суурилуулан шалгаж, нийт 38 байгууллагын 159 албан хаагчид тоног төхөөрөмжийн танилцуулга хийж, цаашдын ашиглалттай холбогдох заавар, зөвлөмж өгч сургалт зохион байгуулсан ба гарын авлага материалаар хангасан. <b>Ажлын гүйцэтгэл 100%.</b></p> <p>Тус ажлын үр дүнд төвөөс алслагдсан аймаг, сумдын төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт хурал уулзалт, сургалтын арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаг хугацаа, зардал хэмнэх боломжуудыг бүрдүүлсэн.</p> <p><i>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин</i></p> <p>2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гол түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлтэй тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.</p> <p>2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p><b>8. Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргааны барилга барих гүйцэтгэгч сонгох ажлын хүрээнд /УАТ 2.08/:</b></p> <p>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/339 дүгээр тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдсан. ТХН, IC Зөвлөх баг, Барилгын зөвлөх багтай 2023 оны 03 дугаар 07-ны өдрийн өдөр тус барилгын ажил болон бусад барилгын ажилд цаашид Фидик гэрээний ямар төрлийг сонгож ашиглах талаар хэлэлцэх уулзалтыг зохион байгуулж, дараах зөвлөмжийг зөвлөх багаас гаргасан. ТХН-ээс KfW-д 2023 оны 03 дугаар 10-ны өдөр төслийн хүрээнд 2023 онд хийхээр төлөвлөж буй барилгын ажлуудад Фидик гэрээний ямар төрлийг сонгож ашиглах болсон тухай зөвшөөрөл хүссэн албан мэйлийг хүргүүлж тус сарын 20-ны өдөр KfW-аас зөвшөөрөл мэйлээр ирүүлээд байна. Тендерийн үнэлгээний хорооны 01 хурлыг 2023 оны 03 дугаар 24-ний</p>
--	--

	<p><b>2-р зорилтын хүрээнд:</b>  <b>Хүрэх үр дүн:</b> Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p> <p>өдөр зохион байгуулж, тендерийн ажлын даалгавар, тендерийн баримт бичгийн төслийг хэлэлцсэнд дагуу ТХН, IC Зөвлөх баг, барилгын зөвлөх баг “Некст степ инженеринг” ХХК-тай 2023 оны 04 дүгээр 10-ны өдөр зохион байгуулсан. IC зөвлөх багийн худалдан авалт хариуцсан зөвлөх Г.Солонгоо, зөвлөх Г.Гансүх нартай хамтран 2023 оны 05 дугаар 05-15-ны өдрүүдэд KfW-ийн барилгын ажлын тендерийн жишиг баримт бичгийн төслийн /англи хувилбар дээр/ ТШӨХ-ийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг шинэчлэн боловсруулж ажилласан. Тус барилгын ажлын зураг төсвийг KfW-ийн зүгээс барилгын мэргэжлийн архитектор хянаж байгаа бөгөөд одоогийн байдлаар ТХН барилгын ажлын зураг төсөвтэй холбоотой хариу хүлээгдэж байна. Тендерийн баримт бичгийн төслийг KfW-ийн үнэлгээний багт 2023 оны 06 дугаар 06-ны өдөр танилцуулсан бөгөөд тус баримт бичгийн БОННМ-ийн шаардлагын хэсгийг KfW банкны БОН-ийн ахлах мэргэжилтэн Карина, IC зөвлөх багийн БОН-ийн асуудал хариуцсан богино хугацааны ОУ-ын зөвлөх Маятай KfW-ийн Худалдан авалт хариуцсан менежер С.Фабиан, ТХН-ийн худалдан авалт хариуцсан ажилтнууд, IC Зөвлөх багийн зөвлөх О.Мэндбаатар, Г.Солонгоо нартай уулзалт зохион байгуулж баримт бичгийг хэлэлцсэн. ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн (KfW) банкны явцын үнэлгээний баг 2023 оны 06 сард Монголд ажилласан томилолтын үр дүнд гарсан хурлын тэмдэглэлд: Олон улсын Тахь групп (ОУТГ) болон ЗБ-тай холбогдсон ч KfW-ийн зүгээс төлөвлөж буй олон үйлдэлт барилгын техникийн зураг төсөлд үл татгалзах өгөөгүй байгаа бөгөөд эдгээр зурагт тодорхой өөрчлөлт оруулахыг ОУТГ-ээс хүссэн. Үнэлгээний багийн зүгээс БОАЖЯ-д а) KfW-ийн асуултуудын хариулт болон АЯАЗ-ын үзэл баримтлалыг ирүүлэх, б) туслах барилгуудын зураг төсөл, дагалдах барилгууд болон тоног төхөөрөмжийн санхүүжилтийг тодорхой болгох шаардлагатай байна гэдгийг сануулсан. Иймд төслийн зөвлөх баг, ТХН-ээс барихаар төлөвлөж байгаа барилгын шинэчилсэн зургийг 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор KfW-д хүргүүлснээр тус ажлын талаарх яриа хэлцлийг үргэлжлүүлэхээр тохирсон. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 0% /2023.01 сард БОАЖЯ KfW банкнаас тусгайлсан зөвшөөрөл авах, 06 сард гэрээ байгуулахаар төлөвлөгөөнд туссан./</b></p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</p> <p><b>6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бутэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</b></p> <p><b>9. (Нэмрөгийн ДЦГ, Их газрын чулууны БЦГ, Говийн их ДЦГ-ын А, Б хэсэг) Хамгаалалтын захиргаадын барилгын нэмэлт ажлын хүрээнд /УАТ 2.09/:</b></p>
--	--

	<p><b>2-р зорилтын хүрээнд:</b>  <b>Хүрэх үр дүн:</b> Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p>	<p>ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн (KfW) банкны явцын үнэлгээний баг 2023 оны 06 сард Монголд ажилласан томилолтын үр дүнд гарсан хурлын тэмдэглэлд: “ Нэмэлт ХЗ-дын барилгын санхүүжилтийн талаар KfW болон БОАЖЯ хоёр хэлэлцүүлгээ үргэлжлүүлэх болно.” гэсний дагуу Хамгаалалтын захиргаадын барилгын нэмэлт ажлын хүсэлтийг БОАЖЯ Сэргээн босголт, зээлийн (KfW) банканд албан ёсоор хүргүүлснээр тус ажлын талаарх яриа хэлцэлийг үргэлжлүүлэхээр тохирсон. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 0% /2023.04 сард Зөвлөх багаас концепци боловсруулж, 06 сард KfW банкнаас зөвшөөрөл авахаар төлөвлөгөөнд туссан./</b></p> <p>10. <b>Баруун бүсийн болон сонгогдсон ТХГН-ийн 7 хамгаалалтын захиргааг бусад тээврийн хэрэгслээр хангах (UTV, завьнууд, трактор, хогны машин, бохир соруулах машин) тендерийн ажлын хүрээнд /УАТ 2.10/:</b> БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/46 дугаартай тушаалаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулгасан. Ажлын даалгавар хэлэлцэх цахим хурлыг ЗБ, ТХН хамтарч 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсны дагуу хэрэгцээт байдлын судалгаа, үнийн судалгаа, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын төслийг орон нутгийн баг, зөвлөх баг боловсруулж ТХН-д 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хүлээлгэж өгсөн.</p> <p>БОАЖЯ-ны ТХБНУГ-ын дарга, төслийн захиралд ажлын даалгаврын төслийг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр танилцуулсны дагуу ТХГНБЗГ-ын ахлах мэргэжилтэн А.Энхжаргалаас тус сарын 31-ний өдөр “Тендерийн ажлын даалгаврыг захиалагч /БОАЖЯ-ны ТХГНБЗГ/ боловсруулж, батлуулсны дараа үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулан, тендерийг зарлана” гэсэн чиглэлийг мэйлээр ТХН-д ирүүлсэн. Үүний дагуу тендерийн ажлын даалгаврын төслийг төслийн захирал болон үнэлгээний хорооны даргад 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүргүүлсэн. ТХН, IC зөвлөх багтай ТХГНБЗГ-ын дарга, төслийн захирал А.Энхжаргал, ТХГНБЗГ-ын төсөл хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, төслийн захирлын зүгээс ТХН, IC зөвлөх багт тодорхой санал өгсний дагуу ажлын даалгаврыг тус оны 06 дугаар сарын 26-ны өдөр батлуулсан. Тендерийн үнэлгээний хорооны 01 хурлыг 07 дугаар сарын эхний 7 хоногт багтаан хуралдуулж, тендерийг зарлахаар төлөвлөн ажиллаж байна. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 30% /2023.12 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./</b></p> <p><b>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга-Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес</b></p>
--	---	---

	<p><b>2-р зорилтын хүрээнд:</b>  <b>Хүрэх үр дүн:</b>          Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p>	<p>3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/</p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт</p> <p>3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.</p> <p><b>11. Орчны бүсийн эргэлтийн сангийн зээлийн үйл ажиллагааны ажлын хүрээнд /YAT 2.11/:</b></p> <p>Тус ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.01-д төлөвлөсөн “Төслийн нэгдүгээр шатанд ТХГН-ийн орчны бүсэд хэрэгжүүлсэн ОБЗЭС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний ажилтай уялдан хийгдэх бөгөөд 2023 оны 09 дүгээр сард хүлээн авах тайлангийн үр дүнд үндэслэн хэрэгжихээр төлөвлөгдсөн. <b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хугацаа болоогүй тул үнэлэхгүй.</b> /2023.12 сар дуустал хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд туссан/</p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем</p> <p>8.2.4. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.</p> <p>Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд зэлтэй амьдрах орчин</p> <p>2.5.20. <u>Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэй стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.</u></p> <p><b>12. Бэлчээр, ой, амьжиргаа сайжруулах ажлуудын менежментийг дэмжих ажлын хүрээнд /YAT 2.12/:</b></p> <p>Бэлчээр, ойн менежментийн концепци боловсруулах Зөвлөх багийн богино хугацааны үндэсний зөвлөх Др. Б.Эрдэнэбаатарыг 2023 оны 05 дугаар сарын 20, Др. Н.Хонгорыг тус оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс тус тус гэрээ байгуулан ажиллаж байна. Богино хугацааны зөвлөхүүдийн ажлын боломжоос шалтгаалж 2 сарын</p>
--	--	--

	<p>хоцрогдолтой байгаа. ОБ-ийн иргэдийн амьжиргааг дэмжих талаар үзэл баримтлалыг боловсруулж 2022 оны 12 дугаар сард ХБНГУ-ыг Сэргээн босголт, зээлийн (KfW) банканд хүргүүлсэн.</p> <p><b>Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу хоцрогдолтой 50% /2023.06 сард БОАЖЯ KfW банкнаас тусгайлсан зөвшөөрөл авахаар төлөвлөгөөнд туссан./</b></p> <p>Богино хугацааны зөвлөхүүд нь бэлчээр, ойн менежментийн концепцийг боловсруулж 2023 оны 08 дугаар сард багтаан боловсруулж KfW-д хүргүүлж зөвшөөрөл авсны дараа бэлчээр, ойн менежментийг сайжруулах үйл ажиллагаанууд 2024 оны төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж эхэлнэ.</p> <p><b>Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 2-ын хүрээнд нийт 12 ажил төлөвлөснөөс 3 ажил хугацаа болоогүй буюу үнэлэхгүй, 3 ажил 100%, 1 ажил 50%, 2 ажил 30%, 3 ажил 0%-тай үнэлэгдэж байна. Зорилт 2-ын дундаж үнэлгээ 45,5%.</b></p>
